

Сэдэв, гол санаанд
тохируулан үйл
явдлыг сонгон бичих



Сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг бичих

цогцолбор 3

Эхийн гол санааг
агуулна

Эцэс сүүлд нь багш инээмсэглэн байж, “Хүний **уучлахгүй байх нь** тэднийг бус, өөрийгөө шийтгэж байдаг.” гэдгийг л та нарт ухааруулах гэсэн юм. “Бусдын алдааг **уучлахгүй бол** бид сэтгэлдээ энэ төмс шиг хүнд ачааг тээж явдаг юм. Бусдыг **уучилна гэдэг** өөрөө өөртөө хийж байгаа сайн зүйл юм шүү дээ” гэж хэлжээ.

гол санааг
дүгнэсэн

сэдэв

уучлал

гол санааг
илэрхийлсэн
өгүүлбэр

Бусдыг **уучилна гэдэг**
өөрөө өөртөө хийж байгаа
сайн зүйл юм шүү дээ” гэж
хэлжээ.

Уучилна гэдэг сайн үйл мөн

Уучилна гэдэг ухаан юм

Сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг бичих

Зургийн үйл явдлыг ноороглон бичье



Сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг бичих

Нэгэн гэр бүл хөрс хагалан ямар нэг цэцэг, ургамал, мод тарихаар шийджээ. Аав нь газар хагалж, ээж нь тармуураар шороог тэгшлэн, хүү нь тоглоомынхоо хүрзийг барин бас л газар хагалах ажилд тусалж байв.

Хөрсөө бэлтгэсний дараа гэр бүлээрээ цэцэгний үрээ суулгалаа

Цэцэгний үрээ суулгаж дуусаад усалжээ.

Тарьсан цэцгээ арчлан зэрлэгийг нь түүж өдөржин борви бохисхийлгүй ажиллана.

Сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг бичих



Сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг бичих

Цэцэг нь сайхан ургаж, гэр бүлээрээ түүнийгээ харан сэтгэл хангалуун харж зогсдог байлаа.

Маргааш аав нь олон сайхан цэцэг дундаас нэгэн цэцгийг их л нямбайлан авч ээжид нь бэлэглэж гэнэ.

Энэ бүхнийг харж зогссон хүү, аав ээж хоёрыгоо гэртээ орсны хойно жигдрэн ургасан бүх цэцгүүдийг тасдан тэвэрлээ.

Сайхан цэцгүүдийг тасдаад бүгдийг нь тэврэн инээмсэглэн зогсож байгаа хүүгээ хараад ээж аав хоёр нь уулга алдан өөрийн эрхгүй нүүрээ дараад харамсан эргэлээ.

Сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг бичих

Сэдэв: хүүхдийн хүмүүжил



Гол санаа: хүүхэд бол гэр бүлийн
тусгал

Сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг бичих

Нэгэн гэр бүл хөрс хагалан ямар нэг цэцэг, ургамал, мод тарихаар шийджээ. Аав нь газар хагалж, ээж нь тармуураар шороог тэгшлэн, хүү нь тоглоомынхоо хүрзийг барин бас л газар хагалах ажилд тусалж байв.

Цаг хугацаа, газар орны байдлыг нэмж дүрсэлж болно

Хаврын сайхан өдөр, өглөө, цэлмэг тэнгэрт наран мандсан гэгээн сайхан өглөө, зуслан дээрээ, хашаан дотроо, хашааныхаа зүүн урд, баруун хэсэгт, ирж яваа цагт, усны шувууд айлчлан ирж, гол ус цөнгөө түрэх цагаар,

Сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг бичих

Хөрсөө бэлтгэсний дараа гэр бүлээрээ цэцэгний үрээ суулгалаа.

Цэцэгний үрээ суулгаж дуусаад усалжээ.

Цэцэг нь сайхан ургаж, гэр бүлээрээ түүнийгээ харан сэтгэл хангалуун харж зогсдог байлаа.

Маргааш аав нь олон сайхан цэцэг дундаас нэгэн цэцгийг их л нямбайлан авч ээжид нь бэлэглэж гэнэ.

Үйл явдал өрнөх болсон шалтгаан

зангилаа

үйл явдлын өрнөл
үйл явдлын дараалал

Гэртээ
Эхээ дэлгэрүүлэн бичиж ирээрэй.